



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 07 сарын 28 өдөр

Дугаар А/227

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.4-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагыг Нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллээр хангах ерөнхий журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагыг Нисэхийн өгөгдөл, мэдээллээр хангах мэдээлэгч нарын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2.Журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан Иргэний нисэхийн ерөнхий газрын Агаарын навигаци, нисэх буудлын бодлого зохицуулалтын газар, Иргэний нисэхийн үндэсний төвийн Агаарын навигацийн үйлчилгээний газар, тус төвийн харьяа Холбоо, навигаци ажиглалтын алба, Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба, Гэрэл суулт, цахилгаан хангалтын алба болон ИНД-139-ийн дагуу аэродромын үйлчилгээ эрхлэгч байгууллагуудад танилцуулах сургалт зохион байгуулахыг Нисэхийн сургалтын төв (Б.Урантөгс)-д, томилогдсон мэдээлэгчтэй албан ёсны зохицуулалтын баримт бичгийг байгуулж, нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллийн урсгалын тогтолцоог бий болгон мөрдөж ажиллахыг Нисэхийн мэдээллийн үйлчилгээний алба (Б.Төгсөө)-нд тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газрын Агаарын навигаци, нисэх буудлын бодлого зохицуулалтын газар (Ч.Одгэрэл)-т, Иргэний нисэхийн үндэсний төв (Н.Батсайхан)-д тус тус даалгасугай.

4.Энэ тушаал гарсантай холбоотой Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2020 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/300, 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/01 дугаар тушаалуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.


ДАРГА



Ч.МӨНХТУЯА

13120 0017

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын  
2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн  
А/27 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



**НИСЭХИЙН МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
БАЙГУУЛЛАГЫГ НИСЭХИЙН ӨГӨГДӨЛ, НИСЭХИЙН  
МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ ЕРӨНХИЙ ЖУРАМ**

### ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

Өөрчлөлтийн дугаар	Огноо	Баталгаажуулсан тушаал	Өөрчлөлтийн утга
01	2011.04.12	A/168 дугаар тушаалаар	Анхны хэвлэл
02	2016.06.13	A/414 дугаар тушаалаар	Энэхүү журамд дараах өөрчлөлтүүд орсон. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>Мэдээлэгчийн эрх үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхой болгосон.</li> <li>НМҮБ-ын эрх үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхой болгосон.</li> <li>Гэрээ, журам боловсруулах багийн хийх ажлыг тодорхой болгосон.</li> <li>Гэрээ байгуулах, журам боловсруулах үйл явцыг тодорхой болгосон.</li> </ul>
03	2020.05.08		Энэхүү журамд дараах өөрчлөлтүүд орсон. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцийн Хавсралт 15-ын 40 дүгээр нэмэлт өөрчлөлт, PANS-AIM Doc 10066-тай холбоотой өөрчлөлтүүдийг оруулсан.</li> <li>Томилогдсон мэдээлэгчтэй байгуулах гэрээ журамд агуулагдах мэдээлэлд өөрчлөлт оруулсан.</li> <li>Мэдээлэл хариуцах ажилтны сургалттай холбоотой заалтыг оруулсан.</li> </ul>
04	2023.07.17		<ul style="list-style-type: none"> <li>Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 04 сарын 12-ны А/94 тоот тушаалын хавсралт ИНД-ийн нэр томъёоны тайлбарын дагуу нэр томъёонд өөрчлөлт оруулсан;</li> <li>ICAO-гийн ANNEX 15-ын Exchange of aeronautical data and aeronautical information хэсэг дэхь Formal arrangement буюу "Албан ёсны зохицуулалтын баримт бичиг" гэх ерөнхий нэршилтэй байхаар шинэчилсэн ба доорх баримт бичгүүдийг агуулна. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>Хамтын ажиллагааг зохицуулах журам</li> <li>Хамтран ажиллах гэрээ</li> <li>Нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллээр хангах зохицуулалт</li> </ul> </li> <li>PANS-AIM DOC 10066-ийн 1 дүгээр өөрчлөлтийн дагуу AD 2.25 "Visual segment surface (VSS) penetration" -ийн мэдээллийг ИНЕГ-ын даргын 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/01 тушаалын хавсралтад нэмж оруулсан.</li> <li>НМҮБ-ыг нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллээр ханган ажиллах ажилтан нь ИНЕГ-ын Нисэхийн сургалтын төвийн "Томилогдсон мэдээлэгчийн сургалт"-д хамрагдаж гэрчилгээжсэн байна" гэснийг "Томилогдсон мэдээлэгчийн сургалт"-д хамрагдсан байна болгон өөрчилсөн.</li> <li>Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалт хариуцсан нэгжийн холбогдох байцаагчийг, Албан ёсны зохицуулалтын баримт бичгийн боловсруулах багт</li> </ul>

Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагыг  
нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллээр хангах ерөнхий журам

			шаардлагатай тохиолдолд оролцуулна гэсэн заалтыг хассан.
--	--	--	--

## АГУУЛГА

1. Ерөнхий зүйл
    - 1.1 Үндсэн зорилго
    - 1.2 Зохицуулалтын баримт бичиг
    - 1.3 Нэр томъёо, тодорхойлолт
  2. Хамтын ажиллагаа
    - 2.1 Томилогдсон мэдээлэгчийн хариуцах үйл ажиллагаа
    - 2.2 Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагын хариуцах үйл ажиллагаа
  3. Албан ёсны зохицуулалтын баримт бичиг боловсруулах баг
- Хавсралт / Албан ёсны зохицуулалтын баримт бичиг боловсруулах үйл явц /

## НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

### 1.1. Үндсэн зорилго

Энэхүү журмын зорилго нь томилогдсон мэдээлэгч Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллага (цаашид "НМҮБ" гэх)-ыг нисэхийн өгөгдөл болон нисэхийн мэдээллээр хангах үйл ажиллагааг зохицуулахад оршино.

### 1.2. Зохицуулалтын баримт бичиг

Энэхүү журам нь Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.4, ICAO-гийн Annex 15-ын Бүлэг 2-ын 2.1.5 болон PANS-AIM DOC 10066-ын Бүлэг 2-ийн 2.1.1 дүгээр заалтуудыг тус тус үндэслэн боловсруулагдсан болно.

### 1.3. Нэр томьёо, тодорхойлолт

Энэхүү баримт бичигт Монгол Улсын стандарт MNS 6409:2015 "Нэр томьёо, тодорхойлолт" ба "ИНД-ийн нэр томьёоны тайлбар"-т орсон нэр томьёонуудыг ашиглахаас гадна дараах тодорхойлолтуудыг ашиглана. Үүнд:

- **Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллага /НМҮБ/** гэж ИНД-175 "Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллага, гэрчилгээжүүлэлт"-ээр гэрчилгээжсэн нисэхийн өгөгдөл болон нисэхийн мэдээлэл хүлээн авах байгууллагыг хэлнэ.
- **Томилогдсон мэдээлэгч** гэж дараах байгууллага, албан тушаалтнуудыг хэлнэ. Үүнд:
  - ИНЕГ-ын даргын тушаалаар томилогдсон байгууллага;
  - НМҮБ-тай албан ёсны зохицуулалтын баримт бичиг байгуулсан МУ-ын агаарын навигацийн тогтолцоонд үйлчилгээ үзүүлдэг байгууллага, түүний албан тушаалтнууд;
  - Нисэхийн аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага;
- **Албан ёсны зохицуулалтын баримт бичиг (formal arrangement)** гэж НМҮБ нь ИНЕГ-ын харьяа болон харьяа бус байгууллагуудтай хамтын ажиллагааг зохицуулах зорилгоор байгуулах баримт бичгийг хэлнэ.
  - **Гэрээ** гэж НМҮБ болон ИНЕГ-ын харьяа бус байгууллагууд хоорондын байгуулсан баримт бичгийг хэлнэ.
  - **Журам** гэж НМҮБ болон ИНЕГ-ын харьяа байгууллагууд хоорондын хамтын ажиллагааг зохицуулах эрх зүйн баримт бичгийг хэлнэ.
  - **Нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллээр хангах зохицуулалт** гэж НМҮБ болон ИНЕГ-ын харьяа бус байгууллагын хэлтэс эсхүл нэгж хооронд байгуулсан баримт бичгийг хэлнэ.

- **Албан ёсны зохицуулалтын баримт бичгийг боловсруулах баг** гэж НМҮБ болон Томилогдсон мэдээлэгчийн төлөөллөөс бүрдсэн албан ёсны зохицуулалтыг боловсруулж батлуулах үйл явцыг гүйцэтгэх баг.

## **ХОЁР. ХАМТЫН АЖИЛЛАГАА**

### **2.1 Томилогдсон мэдээлэгчийн хариуцах үйл ажиллагаа**

- 2.1.1. Томилогдсон мэдээлэгч нь НМҮБ-ыг PANS-AIM DOC 10066-ын Нэмэлт хавсралт 1 "Нисэхийн өгөгдлийн каталог"-т нийцсэн, чанарын шаардлага хангасан өгөгдөл, мэдээллээр хангана.
- 2.1.2. Томилогдсон мэдээлэгч нь нисэхийн өгөгдөл болон нисэхийн мэдээллээр НМҮБ-ыг хангах зорилгоор НМҮБ-тай албан ёсны зохицуулалтын (formal arrangement) баримт бичгийг байгуулан ажиллана.
- 2.1.3. Томилогдсон мэдээлэгч талаас албан ёсны зохицуулалтын баримт бичиг боловсруулах багт орж ажиллах төлөөллийг томилно.
- 2.1.4. Албан ёсны зохицуулалтын баримт бичигт тусгасан НМҮБ-ыг нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллээр ханган ажиллах ажилтан нь ИНЕГ-ын Нисэхийн сургалтын төвийн "Томилогдсон мэдээлэгчийн сургалт"-д хамрагдсан байна.
- 2.1.5. Томилогдсон мэдээлэгч нь НМҮБ-тай албан ёсны зохицуулалтын баримт бичгээр хүлээсэн үүргээ биелүүлнэ.
- 2.1.6. Томилогдсон мэдээлэгч албан ёсны зохицуулалтын баримт бичигт заасан чанарын шаардлагыг хангаагүй нисэхийн мэдээлэл, нисэхийн өгөгдөл дамжуулснаас үүсэх хариуцлагыг хүлээнэ.
- 2.1.7. Албан ёсны зохицуулалт (formal arrangement)-ын баримт бичиг нь нисэхийн мэдээлэл, нисэхийн өгөгдлөөр хангах зохицуулалт, хамтын ажиллагааг зохицуулах журам, хамтран ажиллах гэрээ хэлбэртэй байна.
- 2.1.8. Томилогдсон мэдээлэгч нь хариуцаж буй мэдээлэл өгөгдлүүдэд албан ёсны зохицуулалтын баримт бичигт тусгагдсан хугацаанд дүн шинжилгээ хийж НМҮБ-д хүргүүлнэ.
- 2.1.9. Томилогдсон мэдээгч нь албан ёсны зохицуулалтын баримт бичигт тусгагдсан шалгуур үзүүлэлтүүдэд үндэслэн хэрэгжилтийг жилд 1 удаа үнэлсэн байна.

### **2.2. Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагын хариуцах үйл ажиллагаа**

- 2.2.1. НМҮБ-аас албан ёсны зохицуулалтын баримт бичгийг боловсруулах багт орж ажиллах төлөөллийг томилно.
- 2.2.2. НМҮБ нь албан ёсны зохицуулалтын баримт бичигт тусгагдсан шалгуур үзүүлэлтүүдэд үндэслэн хэрэгжилтийг жилд 1 удаа үнэлсэн байна.
- 2.2.3. НМҮБ нь албан ёсны зохицуулалтын баримт бичгээр хүлээсэн үүргээ биелүүлнэ.

- 2.2.4. НМҮБ нь Томилогдсон мэдээлэгчээс ирүүлсэн чанарын шаардлагыг хангасан нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллээр Нисэхийн мэдээллийн бүтээгдэхүүн боловсруулан тараах үүрэг хүлээнэ.
- 2.2.5. НМҮБ нь хүлээн авсан чанарын шаардлага хангаагүй нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллийг боловсруулан тараахгүй байх эрхтэй.
- 2.2.6. НМҮБ нь хүлээн авсан чанарын шаардлага хангасан өгөгдлийг цаг хугацаанд нь боловсруулан тараагаагүй болон өгөгдлөөс зөрүүтэй, ташаа мэдээлэл боловсруулан тарааснаас үүсэх хариуцлагыг хүлээнэ.
- 2.2.7. Гэрчилгээжээгүй аэродромын хувьд томилогдсон мэдээлэгч нь НМҮБ-ыг шаардлагатай нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллээр хангаагүй эсхүл аэродромын өгөгдөл, мэдээлэлд орсон аливаа өөрчлөлтийг НМҮБ-д мэдэгдэж дүрмийн шаардлагын дагуу баталгаажуулаагүй бол тухайн аэродромын өгөгдөл, мэдээллийг Монгол Улсын AIP-аас хасна.

#### **ГУРАВ. АЛБАН ЁСНЫ ЗОХИЦУУЛАЛТЫН БАРИМТ БИЧГИЙГ БОЛОВСРУУЛАХ БАГ**

- 3.1. Албан ёсны зохицуулалтын баримт бичгийг боловсруулах баг нь НМҮБ-ыг нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллээр хангуулах зорилгоор зохицуулалтын баримт бичгийг боловсруулан Удирдах албан тушаалтнаар батлуулах үүрэг хүлээнэ.
- 3.2. Албан ёсны зохицуулалтын баримт бичгүүд нь дараах агуулгатай байна. Үүнд:
  - a) Зорилго;
  - b) Зохицуулалтын баримт бичгүүд;
  - c) Нэр томъёо, тодорхойлолт;
  - d) Товчилсон үгсийн тайлбар;
  - e) Цаг хугацааны шаардлага;
  - f) Өгөгдлийн хэлбэрийн шаардлага;
  - g) Мэдээлэгчийн хариуцах нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллийн хамрах хүрээ болон чанарын шаардлага;
  - h) Нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээлэл дамжуулах сувгууд;
  - i) Томилогдсон Мэдээлэгч болон НМҮБ-ын эрх, үүрэг;
  - j) Томилогдсон Мэдээлэгч болон НМҮБ-ын хүлээх хариуцлага;
  - k) Албан ёсны зохицуулалтын баримт бичгийн хэрэгжилтийг үнэлэх, үл нийцлийг илтгэх;
  - l) Албан ёсны зохицуулалтын баримт бичигт дүн шинжилгээ хийх, өөрчлөлт оруулах;
  - m) Хариуцах ажилтнууд;
  - n) Томилогдсон хариуцах ажилтнууд;
- 3.3. Томилогдсон мэдээлэгчийн хариуцах өгөгдөл, мэдээллийг PANS-AIM DOC 10066-ын Нэмэлт хавсралт 1-д тусгагдсаны дагуу нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллийг албан ёсны зохицуулалтын баримт бичигт хавсралтаар дэлгэрэнгүй зааж өгнө.
- 3.4. Албан ёсны зохицуулалтын баримт бичигт нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллээр хангахаас бусад үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтыг оруулж болно.




- 3.5. Албан ёсны зохицуулалтын баримт бичиг боловсруулах баг нь зохицуулалтын баримт бичгийг холбогдох эрх бүхий албан тушаалтнаар гарын үсэг зуруулж, баталгаажуулна.
- 3.6. Албан ёсны зохицуулалтын баримт бичиг боловсруулах баг нь гэрээ, журам, нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллээр хангах зохицуулалтын төслийг Хавсралтад заасан үйл явцын дагуу боловсруулна.

---oOo---

**ХАВСРАЛТ**

**АЛБАН ЁСНЫ ЗОХИЦУУЛАЛТЫН БАРИМТ БИЧГИЙГ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ ЯВЦ**





Иргэний нисэхийн ерөнхий газрын да  
2023 оны ... дугаар сарын ...-ний өдрийн ..... ду  
тушаалын хоёрдугаар хавс

**НИСЭХИЙН МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫГ  
НИСЭХИЙН ӨГӨГДӨЛ, НИСЭХИЙН МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ МЭДЭЭЛЭГЧ НАРЫН ЖАГСАЛТ**

Мэдээлэгч	Тогтмол шинж чанартай мэдээлэл болон Тур шинж чанартай 3 сараас дээш хугацаатай мэдээлэл	Тур шинж чанартай 3 сараас доош хугацаатай мэдээлэл
1 Нисэхийн аюулгүй ажиглагааны зохицуулалт байгууллага	<p>ИНЕГ-ын харьяа бүтцийн нэгж</p> <ul style="list-style-type: none"><li>- Ерөнхий дүрэм ба журмууд (Улс дотор баримталж буй):<ul style="list-style-type: none"><li>o Ерөнхий дүрмүүд</li><li>o Ил харааны нислэгийн дүрмүүд</li><li>o Хэрэглэгийн нислэгийн дүрмүүд</li></ul></li><li>- Алтиметрийн тохируулгын журмууд</li><li>- ИСАО-ийн стандарт, практик зөвлөмж ба журмуудаас зөрүүтэй байдлууд</li><li>- Аэродромын гэрчилгээжүүлэлтийн байдал</li><li>- Агаарын хөлгийн хэрэглэл, төхөөрөмж ба нислэгийн баримт бичгүүд</li><li>- Агаарын хөлгийн үндэсний харьяалал болон бүртгэлийн дугаар</li><li>- Иргэний агаарын хөлгийг албадан саатуулах</li><li>- Хөндлөнгийн хууль бус халдлага</li><li>- Нислэгийн хөдөлгөөний зөрчлүүд</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>- Аэродромын гэрчилгээжүүлэлтийн байдал</li></ul>
2 Агаарын бодлого байгууллага	<ul style="list-style-type: none"><li>- Ашиглаж болох минимум шилжих түвшин</li><li>- Агаарын зайн зохион байгуулалт (ENR)<ul style="list-style-type: none"><li>o НХУ-ний агаарын зайн ангилал ба дүрслэл;</li><li>o Бусад зохицуулагдсан агаарын зай</li></ul></li><li>o Нислэгийн минимум өндрийн-түвшин</li><li>o Радио навигацгийн туслах төхөөрөмжүүд/системүүд</li><li>- Нислэгийн замүүд<ul style="list-style-type: none"><li>o Уламжлалт навигацгийн замүүд</li><li>o Бүсийн навигацгийн замүүд</li><li>o Бусад нислэгийн замүүд</li></ul></li><li>- Бус нутгийн нэмэлт журмууд</li><li>- Навигацийн анхааруулгууд:<ul style="list-style-type: none"><li>o Хориотой, хязгаарлалттай болон аюултай бүсүүд</li></ul></li></ul>	



	<ul style="list-style-type: none"> <li>o Цэргийн дадлага сургуулигтийн бус болон агаарын довтолгооноос хамгаалах бус</li> <li>o Бусад аюултай үйл ажиллагаанууд ба болзошгүй аюулууд <ul style="list-style-type: none"> <li>o Агаарын спорт болон соёл амралтын үйл ажиллагаанууд</li> </ul> </li> <li>- НХУ-ний агаарын зай (AD 2.17)</li> <li>- НХУ-ний холбооны байгуламжууд (AD 2.18)</li> <li>- Радио навигацийн болон буултын туслах төхөөрөмжүүд/системүүд, түүний зориулалт (AD 2.19)</li> <li>- Хэмжих систем: <ul style="list-style-type: none"> <li>o Хэмжих нэгж</li> <li>o Хугацааны тооллын тогтолцоо</li> <li>o Хэвтээ лавлагааны тогтолцоо</li> <li>o Босоо лавлагааны тогтолцоо</li> </ul> </li> <li>- Нислэгийн замын хүлээх нислэг</li> </ul>	
3	<p>Нисэх буудлуудын бодлого хариуцсан байгууллага</p> <ul style="list-style-type: none"> <li>- Аэродром/хэлипортуудын ашиглалт ба ашиглалтын нөхцлүүд</li> <li>- Аэродром болон хэлипортуудын индекс</li> <li>- Аэродром/хэлипортуудын ангилал</li> </ul>	
4	<p>Иргэний нисэхийн дүрмийн боловсруулалт хариуцсан байгууллага</p> <ul style="list-style-type: none"> <li>- Нисэхийн мэдээллийн үйлчилгээний хэвлэлүүдэд ашиглагдах товчлолууд</li> <li>- Үндэсний зохицуулалтууд болон олон улсын гэрээ/конвенцын хураангуй</li> </ul>	
5	<p>Аэродром болон агаарын навигацийн үйлчилгээний хураамж хариуцсан байгууллага</p> <ul style="list-style-type: none"> <li>- Нислэгийн зам болон аэродром/хэлипортын төлбөр хариуцсан байгууллагын мэдээлэл</li> <li>- Аэродром/хэлипортын хураамжууд</li> <li>- Агаарын навигацийн үйлчилгээний хураамжууд</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Аэродромын хураамжууд</li> <li>- Агаарын навигацийн үйлчилгээний хураамжууд</li> </ul>
<b>ИНТУ-ийн харьяа бүтцийн нэгж</b>		
1	<p>Агаарын навигацийн үйлчилгээ хариуцсан байгууллага</p> <ul style="list-style-type: none"> <li>- Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний ажиглалтын үйлчилгээ ба журмууд: <ul style="list-style-type: none"> <li>o Ажиглалтын хоёрдогч радар</li> <li>o Автомат хамааралтай ажиглалт – радио нэвтрүүлэг (ADS-B)</li> <li>o Холбогдох бусад мэдээлэл ба журмууд</li> </ul> </li> <li>- Нислэгийн төлөвлөгөө, мэдээг хаяглан явуулах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Агаарын зайн зохион байгуулалт</li> <li>- Агаарын зам, түүний сегмент, Агаарын зам, хамааралтай мэдээллүүд</li> <li>- Нислэгийн хөдөлгөөний журмууд</li> <li>Навигацийн анхааруулга:</li> <li>- Агаарын зайн хязгаарлалт</li> <li>- Анхааруулга</li> </ul>
2	<p>Нисэх буудлуудын үйлчилгээ хариуцсан байгууллага</p> <ul style="list-style-type: none"> <li>- Аэродром орчим дах шувуудын бөөгнөрөл</li> <li>- Шувуудын нүүдэл ба зэрлэг ан амьтны бусууд</li> <li>- Авран туслах, гал унтраах үйлчилгээ ба цасны төлөвлөгөө</li> </ul>	

3	<p>Нислэгийн төлөвлөлт хариуцсан Байгууллага</p> <p>урсгал хариуцсан</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Агаарын хөлөг нисэн ирэх, дамжин өнгөрөх ба нисэн гарах</li> <li>- Нислэгийн хөдөлгөөний урсгалын менежмент ба агаарын зайн менежмент</li> <li>- Нислэгийн төлөвлөлт</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Агаарын хөлөг нисэн ирэх, дамжин өнгөрөх ба нисэн гарах</li> <li>- Нислэгийн хөдөлгөөний урсгалын менежмент ба агаарын зайн менежмент</li> <li>- Нислэгийн төлөвлөлт</li> </ul>
4	<p>ИНД-139-ийн аэродромын эрхлэгч Байгууллага</p> <p>дагуу үйлчилгээ</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Аэродром/хэлипортын хураамжууд, төлбөртэй хамааралтай байгууллагын хаяг (байгаа тохиолдолд)</li> <li>- Аэродромын байршил заах код ба нэр</li> <li>- Аэродромын газарзүйн болон захиргааны өгөгдөл</li> <li>- Үйл ажиллагааны цагийн хуваарь</li> <li>- Газрын үйлчилгээ болон байгууламжууд</li> <li>- Зорчигчдад үйлчлэх байгууламжууд</li> <li>- Улирлын чанартай цэвэрлэгээний үйл ажиллагаа</li> <li>- Агрон, явгалах зам ба шалгах байрлал/байршлуудын өгөгдөл</li> <li>- Гадаргуугийн хөдөлгөөнийг чиглүүлэх болон удирдах систем ба тэмдэглэгээнүүд</li> <li>- Аэродромын саадүүд</li> <li>- Хөөрч буух зурвасны бодит үзүүлэлтүүд</li> <li>- Зарласан зайнууд</li> <li>- Нисдэг тэрэгний буултын талбай</li> <li>- НХУ-ний холбооны байгууламжууд (ИНЕГ-ын харьяа бус)</li> <li>- Радио навигацийн болон буултын туслах төхөөрөмжүүд (ИНЕГ-ын харьяа бус)</li> <li>- Аэродромын дотоод зохицуулалтууд</li> <li>- Дуу багасгах журмууд</li> <li>- Нэмэлт мэдээлэл</li> <li>- Аэродромд хамааралтай зургуудыг боловсруулахад шаардлагатай хэмжилтийн файлууд</li> <li>- Авран туслах, гал унтраах үйлчилгээ ба цасны төлөвлөгөө (байгаа тохиолдолд)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Аэродромын гэрэлтүүлгийн байгууламжууд</li> <li>- Буултын болон хөдөлгөөн талбай</li> <li>- Аэродромын туслах төхөөрөмжүүд боло</li> <li>- Холбооны байгууламжууд</li> <li>- Навигацийн байгууламжууд</li> <li>- Буултын туслах төхөөрөмжүүд/систем</li> <li>- Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ</li> <li>- Саадны мэдээлэл</li> </ul>
5	<p>Гэрэл суулт, цахилгаан хангалт хариуцгч Байгууллага</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Ойртолгтын болон ХБЗ-ны гэрэлтүүлэг</li> <li>- Бусад гэрэлтүүлэг болон цахилгаан хангамжийн хоёрдогч эх үүсвэр</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Аэродромын гэрэлтүүлгийн байгууламжууд</li> </ul>
6	<p>ИНД-171-ээр гэрчилгээжсэн байгууллага</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Радио навигацийн боло</li> <li>- Буултын туслах төхөөрөмжүүд</li> <li>- Холбооны байгууламжууд</li> <li>- Ажиллалтын байгууламжууд</li> <li>- Цаг уурын үйлчилгээний төхөөрөмжүүд</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Холбоо болон навигацийн үйлчилгээ:</li> <li>- Хариуцах байгууллага</li> <li>- Хариуцлагын бүс</li> <li>- Үйлчилгээний төрлүүд</li> <li>- Шаардлага болон нөхцлүүд</li> <li>- Бусад (радио өргөн нэвтрүүлгийн станцууд, цахилгаан холбоо гэх мэт)</li> <li>- Бусад цаг уурын автоматчлагдсан үйлчилгээний туслах төхөөрөмжүүд</li> <li>- Глобал навигацийн хиймэл дагуулын систем (GNSS)</li> <li>- Нислэгийн замын агаарын навигацийн газрын гэрлүүд</li> </ul>



		<ul style="list-style-type: none"> <li>- Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний: <ul style="list-style-type: none"> <li>o Хариуцах байгууллага</li> <li>o Хариуцлагын бүс</li> <li>o Үйлчилгээний төрлүүд</li> <li>o Үйл ажиллагаа эрхлэгч ба НХУ хоорондын зохицуулалт</li> <li>o НХУ-ний нэгжүүдийн хаягийн жагсаалт</li> <li>- Нислэгийн төлөвлөлт</li> <li>- Нислэгийн журмууд /Flight procedures/</li> <li>- Хүлээх, ойртолт үйлдэх болон нисэн гарах журмууд</li> </ul> </li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Аэродромын мэдээллийн үйлчилгээний төхөөрөмжүүд</li> <li>- Глобал навигацийн хиймэл дагуулын систем (GNSS)</li> </ul>
7	ИНД-172-оор гэрчилгээжсэн байгууллага	<ul style="list-style-type: none"> <li>- Хүлээх, ойртолт үйлдэх, нисэн ирэх болон нисэн гарах нислэгийн журмууд</li> <li>- Шилжих түвшин /Шилжих нислэгийн түвшин</li> <li>- Нислэгийн минимум түвшнийг тогтооход ашигладаг шалгуурууд</li> <li>- Visual segment surface (VSS) penetration</li> <li>- Цаг уурын үйлчилгээ <ul style="list-style-type: none"> <li>o Хариуцах байгууллага</li> <li>o Хариуцлагын бүс</li> <li>o Цаг уурын ажиглалт болон мэдээнүүд</li> <li>o Үйлчилгээний төрлүүд</li> <li>o Нислэгийн операторуудаас шаардах мэдэгдэл</li> <li>o Агаарын хөлгийн мэдээнүүд</li> <li>o VOLMET үйлчилгээ</li> <li>o SIGMET болон AIRMET үйлчилгээ</li> <li>o Бусад цаг уурын автоматчилагдсан үйлчилгээ</li> </ul> </li> <li>- Аэродром/Халипортын хяналтын хэм, дундаж хамгийн бага хэм</li> <li>- Цаг уурын мэдээллийн үйлчилгээний цагийн хуваарь</li> <li>- Цаг уурын мэдээллийн хангалт</li> <li>- Бусад аюултай үйл ажиллагаанууд ба болзошгүй аюулгуудын талаарх мэдээлэл</li> <li>- Нисэхийн мэдээллийн үйлчилгээ <ul style="list-style-type: none"> <li>o Хариуцах байгууллага</li> <li>o Хариуцлагын бүс</li> <li>o Нисэхийн хэвлэлүүд</li> <li>o AIRAC тогтолцоо</li> <li>o Нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээ</li> <li>o Тоон өгөгдлийн багц</li> <li>- Нислэгийн зургууд <ul style="list-style-type: none"> <li>o Хариуцах байгууллага</li> </ul> </li> </ul> </li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Нислэгийн үйлчилгээ</li> <li>- Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ</li> </ul>
8	ИНД-173-аар гэрчилгээжсэн байгууллага	<ul style="list-style-type: none"> <li>- Цаг уурын үйлчилгээ <ul style="list-style-type: none"> <li>o Хариуцах байгууллага</li> <li>o Хариуцлагын бүс</li> <li>o Цаг уурын ажиглалт болон мэдээнүүд</li> <li>o Үйлчилгээний төрлүүд</li> <li>o Нислэгийн операторуудаас шаардах мэдэгдэл</li> <li>o Агаарын хөлгийн мэдээнүүд</li> <li>o VOLMET үйлчилгээ</li> <li>o SIGMET болон AIRMET үйлчилгээ</li> <li>o Бусад цаг уурын автоматчилагдсан үйлчилгээ</li> </ul> </li> <li>- Аэродром/Халипортын хяналтын хэм, дундаж хамгийн бага хэм</li> <li>- Цаг уурын мэдээллийн үйлчилгээний цагийн хуваарь</li> <li>- Цаг уурын мэдээллийн хангалт</li> <li>- Бусад аюултай үйл ажиллагаанууд ба болзошгүй аюулгуудын талаарх мэдээлэл</li> <li>- Нисэхийн мэдээллийн үйлчилгээ <ul style="list-style-type: none"> <li>o Хариуцах байгууллага</li> <li>o Хариуцлагын бүс</li> <li>o Нисэхийн хэвлэлүүд</li> <li>o AIRAC тогтолцоо</li> <li>o Нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээ</li> <li>o Тоон өгөгдлийн багц</li> <li>- Нислэгийн зургууд <ul style="list-style-type: none"> <li>o Хариуцах байгууллага</li> </ul> </li> </ul> </li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Цаг уурын үйлчилгээ</li> </ul>
9	ИНД гэрчилгээжсэн байгууллага	<ul style="list-style-type: none"> <li>- Цаг уурын үйлчилгээ <ul style="list-style-type: none"> <li>o Хариуцах байгууллага</li> <li>o Хариуцлагын бүс</li> <li>o Цаг уурын ажиглалт болон мэдээнүүд</li> <li>o Үйлчилгээний төрлүүд</li> <li>o Нислэгийн операторуудаас шаардах мэдэгдэл</li> <li>o Агаарын хөлгийн мэдээнүүд</li> <li>o VOLMET үйлчилгээ</li> <li>o SIGMET болон AIRMET үйлчилгээ</li> <li>o Бусад цаг уурын автоматчилагдсан үйлчилгээ</li> </ul> </li> <li>- Аэродром/Халипортын хяналтын хэм, дундаж хамгийн бага хэм</li> <li>- Цаг уурын мэдээллийн үйлчилгээний цагийн хуваарь</li> <li>- Цаг уурын мэдээллийн хангалт</li> <li>- Бусад аюултай үйл ажиллагаанууд ба болзошгүй аюулгуудын талаарх мэдээлэл</li> <li>- Нисэхийн мэдээллийн үйлчилгээ <ul style="list-style-type: none"> <li>o Хариуцах байгууллага</li> <li>o Хариуцлагын бүс</li> <li>o Нисэхийн хэвлэлүүд</li> <li>o AIRAC тогтолцоо</li> <li>o Нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээ</li> <li>o Тоон өгөгдлийн багц</li> <li>- Нислэгийн зургууд <ul style="list-style-type: none"> <li>o Хариуцах байгууллага</li> </ul> </li> </ul> </li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Цаг уурын үйлчилгээ</li> </ul>
10	ИНД гэрчилгээжсэн байгууллага	<ul style="list-style-type: none"> <li>- Цаг уурын үйлчилгээ <ul style="list-style-type: none"> <li>o Хариуцах байгууллага</li> <li>o Хариуцлагын бүс</li> <li>o Цаг уурын ажиглалт болон мэдээнүүд</li> <li>o Үйлчилгээний төрлүүд</li> <li>o Нислэгийн операторуудаас шаардах мэдэгдэл</li> <li>o Агаарын хөлгийн мэдээнүүд</li> <li>o VOLMET үйлчилгээ</li> <li>o SIGMET болон AIRMET үйлчилгээ</li> <li>o Бусад цаг уурын автоматчилагдсан үйлчилгээ</li> </ul> </li> <li>- Аэродром/Халипортын хяналтын хэм, дундаж хамгийн бага хэм</li> <li>- Цаг уурын мэдээллийн үйлчилгээний цагийн хуваарь</li> <li>- Цаг уурын мэдээллийн хангалт</li> <li>- Бусад аюултай үйл ажиллагаанууд ба болзошгүй аюулгуудын талаарх мэдээлэл</li> <li>- Нисэхийн мэдээллийн үйлчилгээ <ul style="list-style-type: none"> <li>o Хариуцах байгууллага</li> <li>o Хариуцлагын бүс</li> <li>o Нисэхийн хэвлэлүүд</li> <li>o AIRAC тогтолцоо</li> <li>o Нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээ</li> <li>o Тоон өгөгдлийн багц</li> <li>- Нислэгийн зургууд <ul style="list-style-type: none"> <li>o Хариуцах байгууллага</li> </ul> </li> </ul> </li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Нисэхийн үйлчилгээ</li> <li>- Нисэхийн мэдээллийн үйлчилгээ</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>○ Зургуудын байнгын засвар өөрчлөлт</li> <li>○ Худалдан авах хаяг</li> <li>○ Нислэгийн зургийн сериуд</li> <li>○ Боловсруулан гаргаж буй нислэгийн зургуудын жагсаалт</li> <li>○ Дэлхийн нислэгийн зургийн индекс</li> <li>○ Байр зүйн зургууд</li> <li>○ AIR-д ороогүй зургуудын засвар</li> <li>○ Нислэгийн төлөвлөлт</li> <li>○ Нислэгийн төлөвлөгөө мэдээг хаяглан явуулах</li> <li>○ Аэродром дахь НХУ-ний илтгэх төв (ARO), үйлчилгээний цагийн хуваарь</li> <li>- Нийтээр амрах баярын өдрүүд</li> </ul>	
11	Эрэн хайх, авран туслах үйл ажиллагааг хариуцсан байгууллага	<ul style="list-style-type: none"> <li>- Эрэн хайх ба авран туслах үйлчилгээ: <ul style="list-style-type: none"> <li>○ Хариуцах байгууллага</li> <li>○ Хариуцлагын бүс</li> <li>○ Үйлчилгээний төрлүүд</li> <li>○ Эрэн хайх, авран туслах үйлчилгээний хэлэлцээрүүд</li> <li>○ Үйл ажиллагааны нөхцлүүд</li> <li>○ Ашиглах журам болон дохионууд</li> </ul> </li> </ul>	- Эрэн хайх ба авран туслах үйлчилгээ
12	ИНЕГ болон ИНД 175-аар гэрчилгээжсэн байгууллагатай хамтран ажиллах байгуулсан байгууллагууд	- Бусад мэдээлэл	- Бусад мэдээлэл
14	Бусад орны нисэхийн мэдээллийн үйлчилгээг хариуцсан байгууллагууд		- НӨМУ үзүүлэхэд шаардлагатай нисэхийн мэдээллийн бүтээгдэхүүнүүд

---ОО---